



ДААТГАЛ
SINCE 1994



2020

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Түүхэн замнал





Онцлох үйл явдал 2020

Онцлох үйл явдал 2020




Ard App-д даатгалын цэс шинээр нэмэгдэж, даатгуулагчид түргэн шуурхай даатгалын үйлчилгээг авах боломжтой боллоо.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа анх удаа цахимаар зохион байгуулав.



Нээлттэй хувьцаат компани болсноос хойш 2 дахь жилдээ дараалан хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилав.



Онцлох үйл явдал 2020



Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс ажиллагсдыг гэрээр ажиллах шийдвэр гаргав.



ArdMedicare Олон улсын эрүүл мэндийн даатгалд Covid-19 вирусийн халдварын эрсдэл хамрагддаг боллоо.



Жолоочийн хариуцлагын даатгалдаа "Гэрэгэ киоск"-ыг ашиглан хамрагдах боломжтой боллоо.

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ
ГЭРЭГЭ КИОСК-Д НЭВТЭРЛЭЭ

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ
ГЭРЭГЭ КИОСКООР

БОДЬ ДААТГАЛ ПРАКТИКАЛ
МОНРЕ ДААТГАЛ МОНГОЛ ДААТГАЛ MG

gesystems www.gerege.mn 7777-3773, 8



Засаглал


Хувьцаа эзэмшигчдийн хурал

2020 оны эхний хагас жилд дэлхий дахинаа шинэ коронавирус (COVID-19)-ын халдвар эрчимтэй тархаж, УОК-оос улс орон даяар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал тогтоосон энэ үед Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахимаар (live.ard.mn) амжилттай зохион байгууллаа. Хуралд нийт 22,020,448 ширхэг саналын эрх бүхий хувьцаа

эзэмшигчид оролцож, 88.08 хувийн ирцтэйгээр хуралдан Компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталлаа.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	16,554,425	66.20%
2	Ард Лайф ХХК	1,258,694	5.00%
3	Би Ди Сек ҮЦК ХК	929,529	3.70%
4	Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.30%
5	Бодь Даатгал ХК	496,622	2.00%
6	Бусад	4,939,980	19.80%
	НИЙТ ДҮН (1,951 хувьцаа эзэмшигч)	25,000,000	100.00%

Хувьцааны арилжаа 2020



110 өдөр арилжигдсан	₮630 - ₮798	Огноо	Хаалтын ханш	Арилжааны дүн	Дундаж үнэ	EPS (TTM)
Нийт хувьцааны тоо	25,000,000	2019/6/30	₮769.4 -10%	₮1,464 сая	₮685.3	98.1
Зах зээлийн үнэлгээ	₮17.6 тэрбум	2019/12/31	₮799.9 7%	₮2,177 сая	₮696.7	68.8
Дансны үнэ	₮461.4	2020/6/30	₮704.5 -2%	₮585 сая	₮702.8	38.1
P/E (TTM) - Үнэ/Ашиг	18.5					
P/B - Үнэ/Дансны үнэ	1.5					



Төлөөлөн Удирдах Зөвлөл

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн одоогийн бүрэлдэхүүнийг 2019 оны 4 сарын 27-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2 жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгосон.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2020

Ногдол ашгийн мэдээлэл

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 сарын 17-ны өдрийн №01/20-2 тоот тогтоолоор компанийн 2019 оны цэвэр ашгийн 49.45 хувь буюу нэгж хувьцаанд 34 төгрөг нийт 850 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн

оны эхний хагас жилд ээлжит хурлаа онлайнаар хийсэн бол нийт 5 удаа эчнээ санал хураалт явуулж “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар зарлан хуралдуулах, Ногдол ашиг хуваарилах, Гүйцэтгэх захирлын 2020 оны гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг батлах зэрэг онцлох шийдвэрүүдийг гаргасан байна.

хадгаламжийн төв ХХК (ҮЦТХТ)-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан, тус гэрээний дагуу хувьцаа эзэмшигч тус бүрийн данс руу хуваарилалтыг 2020 оны 5 сарын 27-ны өдөр амжилттай хийж дуусгалаа.





Үйл ажиллагааны тайлан

Удирдлагын баг

Гүйцэтгэх захирлын 2020 оны 4 сарын 21-ний өдрийн А/20/51 тоот тушаалаар компанийн бүтцэд Бүтээгдэхүүн хөгжүүлэлт, эрсдэлийн шинжилгээний хэлтэс шинээр байгуулагдаж, тус хэлтсийн захирлаар Ганболд овогтой Эрдэнэ-Очир томилогдлоо.



Хүний нөөц

Ард Даатгал ХК нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар Даатгалын салбарт мэргэшсэн туршлагатай 98 ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна.


Хамт олны дундаас ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн Даатгалын менежер Т.Мөнхчимэг, Даатгалын менежер Б.Нандинцэцэг нар Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдлаа.

Бид ажиллагсдаа давтан сургах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд анхаардаг бөгөөд гадаадын мэргэшлийн сургалтуудад хамрууллаа. Тухайлбал, Их Британи Улсын “The Chartered Insurance Institute”-ээс зохион байгуулсан “Ердийн даатгалын анхан шатны сургалт”-д Давхар даатгалын ахлах менежер Д.Одмаа, Давхар даатгалын менежер Н.Ачит; Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгээс хамтран ХБНГУ-д зохион байгуулсан “Олон улсын түвшний менежер бэлтгэх сургалт, хөтөлбөр”-т Эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Тайшир нар амжилттай суралцаж, сертификат гардан авлаа.

Даатгалын үйл ажиллагаа

Ард Даатгал ХК нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар 13 даатгалын хэлбэрийн 47 төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, 7.77 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлэн хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг даатган ажиллалаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 тэрбум төгрөгөөр буюу 32.6 хувиар өссөн байна.

Нийт хураамжийн орлого





Компанийн орон нутаг дахь салбарууд нийт 890 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлж хагас жилийн орлогын төлөвлөгөөний 67 хувийг биелүүлж ажиллалаа. Орон нутаг даяар зохион байгуулагддаг авто тээврийн үзлэг оношилгоотой зэрэгцэн даатгалын борлуулалтаар нийт 432 сум багт ажиллаж, нийт 14 мянга гаруй жолоочийн даатгалыг хийж гүйцэтгэжээ.

2020 оны эхний хагас жилд төрийн өмчийн болон орон нутгийн өмчит байгууллагууд мөн хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагын нийт 56 тендер шалгаруулалтад оролцсон байна.

	Орон нутгийн салбар		Төв компани		Нийт дүн	
	2019II	2020II	2019II	2020II	2019II	2020II
Нийт хураамжийн орлого	1,034	890	4,794	6,878	5,858	7,768
Нөхөн төлбөр	293	268	1,788	1,834	2,080	2,102

/сая төгрөг/




Давхар даатгал

Тайлант хугацаанд 6 төрлийн даатгалын 16 давхар даатгалын гэрээ байгуулан 826.16 сая төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын эрсдэлийг 5 нэр бүхий давхар даатгалын Hannover Re, Swiss Re, Allianz, Generali, Mongolia Re компаниудаар

тараан байршуулж 986.98 сая төгрөгийн хураамжийг давхар даатгагчдад шилжүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.7 хувь буюу 119.17 сая төгрөгөөр өссөн байна.

2020 эхний хагас жилийн давхар даатгалын зардлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал: /сая төгрөг/



Нөхөн төлбөр

Ард Даатгал ХК нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар 2,315 даатгуулагчийн 2.1 тэрбум төгрөгийн хохирлыг төлж даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ.

Тайлант хугацаанд манай компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 9 хувь буюу 187 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж үлдсэн хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн.



Бид даатгуулагчдын өмнө хүлээсэн гэрээний үүргээ биелүүлж хохирол тохиолдсон даатгуулагчдад нөхөн төлбөр төлөхийн зэрэгцээ мөн нийт даатгуулагчдын дундын нөөц санг хамгаалж, санг зохистой удирдах үүрэгтэй ажилладаг. 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 107 харилцагчид

181 сая төгрөгийн нэхэмжлэлд татгалзсан шийдвэр гаргаж ажилласан бөгөөд гэрээнд хамрагдахгүй нөхцөлтэй, хохирлыг нотлох боломжгүй, мөн даатгагчийг хууран мэхлэх үйлдлүүд нь нөхөн төлбөр татгалзах голлох шалтгаан болсон байна.



Шүүхээр шийдүүлж буй маргаан

Даатгалын нөхөн төлбөрийн маргаантай холбогдуулан шүүхийн шатанд 5 хэрэгт хариуцагчаар, даатгалын гэрээнээс бусад төрлийн гэрээний 5 маргаанд нэхэмжлэгчээр

оролцсон нь бусад даатгагчидтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт буюу гэрээний үүргээ бүрэн дүүрэн биелүүлж ажиллалаа.



Санхүүгийн байдлын хураангуй тайлан

2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт хураамжийн орлого 7.77 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 33 хувь буюу 1.94 тэрбум төгрөгөөр өссөн бол нийт нөхөн төлбөр 2.10 тэрбум төгрөгт

хүрч өмнөх оны мөн үеэс 1 хувь буюу 21 сая төгрөгөөр тус тус өссөн бол үйл ажиллагааны зардал 2.77 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 5 хувь буюу 156 сая төгрөгөөр буурсан байна.



Санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөг)	2019 Q2	2019 Q4	2020 Q1	2020 Q2
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	676	422	1,155	1,403
Авлага	2,042	1,886	2,575	3,930
Бараа материал	21	29	15	23
Урьдчилж төлсөн тооцоо	2,591	2,097	2,219	2,414
Хөрөнгө оруулалт	15,393	15,180	14,955	14,726
Үндсэн хөрөнгө	1,002	1,037	1,009	977
Биет бус хөрөнгө	231	174	192	210
НИЙТ ХӨРӨНГӨ	21,956	20,824	22,120	23,683
Өр төлбөр	2,379	1,139	1,856	2,104
Нөөц сан	8,139	7,880	8,135	10,044
Үүнээс: ОТХН	5,690	4,875	5,092	7,012
Нөхөн төлбөрийн нөөц сан	2,450	3,005	3,043	3,032
Нийт эздийн өмч	11,438	11,805	12,129	11,535
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ	21,956	20,824	22,120	23,683

Орлого, үр дүнгийн тайлан

(сая төгрөг)	2019 Q2	2019 Q4	2020 Q1	2020 Q2
Нийт хураамжийн орлого	5,828	11,409	2,905	7,768
Давхар даатгал	868	2,082	529	1,182
Буцаасан даатгал	115	431	49	89
Цэвэр хураамжийн орлого	4,845	8,896	2,327	6,496
Орлогод тооцсон хураамж	4,737	9,624	2,244	4,544
Нийт нөхөн төлбөр	2,081	4,423	1,261	2,102
<i>Давхар даатгалаас төлсөн</i>	<i>53</i>	<i>451</i>	<i>162</i>	<i>187</i>
<i>Буруутай этгээдийн хариуцсан</i>	<i>4</i>	<i>12</i>	<i>3</i>	<i>5</i>
Цэвэр нөхөн төлбөр	2,025	3,961	1,096	1,909
Нөөц сангийн өөрчлөлт	117	588	101	45
Хөрөнгө оруулалтын орлого	1,660	2,411	348	731
Үйл ажиллагааны зардал	2,923	6,022	1,077	2,767
Татвар төлөхийн өмнөх ашиг	1,501	2,001	359	663
Орлогын албан татвар	149	282	35	78
ЦЭВЭР АШИГ	1,352	1,719	324	585

Төлбөрийн чадварын үзүүлэлт

Ард Даатгал ХК-ийн төлбөр чадварын үзүүлэлт нь 2020 оны II улирлын байдлаар 123.4 хувьтай байгаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн

биелүүлээд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй, төлбөрийн чадвар нь зохистой түвшинд хангагдсан болохыг илэрхийлж байна.

		2017 Q2	018 Q2	2019 Q2	2020 Q2
Хохирлын харьцаа Loss ratio	Цэвэр НТ/ОТХ	36.6% ⁴	4.7%	42.7% ⁴	2.0%
Зардлын харьцаа Expense ratio	ҮАЗ/ОТХ	76.8%	55.6%	61.7% ⁶	0.9%
Хосолсон харьцаа Combined ratio	LR+ER	113.4% ¹	00.3%	104.4%	102.9%
Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт Solvency	100%-иас дээш байх	101.2%	100.1%	118.7% ¹	23.4%

ХҮЧТЭЙ. ХАМТДАА.